

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 04 дүгээр
сарын 09 -ны өдөр

Дугаар 136 / 77

Улаанбаатар
хот

Журам, зардлын хэмжээ батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.11 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 364 дүгээр тогтоолын 3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийн төсөл боловсруулах, төсвийг хуваарилах, санхүүжүүлэх журам”-ыг нэгдүгээр, Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардлын хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтэс /О.Хуягцогт/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл Мэндийн Сайд, Сангийн Сайдын хамтарсан 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээ батлах тухай” 193/136 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

САНГИЙН САЙД



Ж.ЭРДЭНЭБАТ

Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын
2015 оны 04 сарын 09 өдрийн 18/77 дугаар
хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТӨСВИЙГ ХУВААРИЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар өрхийн эрүүл мэндийн төвийн улсын төсвөөс санхүүжих тусламж, үйлчилгээний төсвийн төслийг (цаашид “Улсын төсвийн төсөл” гэх) боловсруулах, төсвийг хуваарилах, санхүүжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2 Өрхийн эрүүл мэндийн төв нь орон нутгийн төсөв болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжиж болох бөгөөд уг харилцааг холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 1.3 Өрхийн эрүүл мэндийн төвийн улсын төсвийн төслийг боловсруулах, төсвийг хуваарилах, санхүүжүүлэхэд “Нэг иргэнд ногдох зардлаар санхүүжүүлэх” санхүүжилтийн аргыг ашиглана.
- 1.4 Нэг иргэнд ногдох зардлаар санхүүжүүлэх аргын зорилго нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг орон нутгийн хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд үндэслэн тэгш хүртээмжтэй үзүүлэх, тусламж үйлчилгээний чанар, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд санхүүгийн оновчтой хөшүүргийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Төсвийн төсөл боловсруулах, хуваарилах аргачлал

2.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн улсын төсвийн төсөл боловсруулах, хуваарилахад дараах аргачлалыг баримтлана. Үүнд:

- 2.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн улсын төсвөөс санхүүжих нийт зардлын хэмжээ нь эрүүл мэндийн эрсдэлээр ангилсан бүлэг тус бүрт ногдох зардлын нийлбэрээр тодорхойлогдоно.

$$C_{ар_{өрх}} = \sum_{i=1}^n C_{ар_{бүлэг i}}$$

$C_{ар_{өрх}}$ – Өрхийн эрүүл мэндийн төвийн улсын төсвөөс санхүүжих нийт зардлын хэмжээ

$C_{ар_{бүлэг}}$ – Эрүүл мэндийн эрсдлийн бүлгээр ангилсан санхүүжилт

n – Эрүүл мэндийн эрсдлийн бүлгийн тоо

i – Эрүүл мэндийн эрсдэлийн бүлгийн дугаар

- 2.1.2 Эрүүл мэндийн эрсдэлээр ангилсан бүлэг тус бүрийн зардлын хэмжээ нь тухайн бүлэгт хамаарах хүн амын тоо болон тухайн бүлгийн нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардлын үржвэрээр тодорхойлогдоно.

$$C_{арбүлэг} = w_{рор_i} * C_i$$

$C_{арбүлэг}$ – Эрүүл мэндийн эрсдэлээр ангилсан бүлгийн санхүүжилт

$w_{рор_i}$ – Эрүүл мэндийн эрсдэлээр ангилсан бүлэгт хамаарах хүн амын тоо

C – Нэг иргэнд ногдох эрсдэлийн бүлэгт харгалзах суурь зардал

i – Эрүүл мэндийн эрсдэлийн бүлгийн дугаар

2.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийн төсөл боловсруулахад хүн амын хүчин зүйлсийн нөлөөллийг тооцохдоо Үндэсний статистикийн хорооноос хамгийн сүүлд албан ёсоор нийтэлсэн суурин хүн амын тоог баримтлан тооцно.

2.3 Нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардал гэдэг нь “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний багцад хамаарах тусламж, үйлчилгээ”-г иргэнд тухайн жилд үзүүлэх тусламж үйлчилгээний зардал болно.

Гурав. Төсвийн төсөл боловсруулах, хуваарилах үйл ажиллагаа

3.1 Өрхийн эрүүл мэндийн төв нь улсын төсвийн төсөл боловсруулахдаа Төсвийн тухай хууль болон энэхүү журмын 2-т заасан аргачлалыг баримтлана.

3.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар энэхүү журмын 2-т заасан аргачлалын дагуу хуваарилах ба төсвийн төслийг батлуулахад тооцсон хүн амын тоо, нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардлыг ашиглана.

Дөрөв. Төсөв санхүүжүүлэх үйл ажиллагаа

4.1 Өрхийн эрүүл мэндийн төвийг санхүүжүүлэх үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу орон нутаг төлөөлөн хэрэгжүүлнэ.

4.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг нэг иргэнээр тооцож санхүүжүүлэх бөгөөд, зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

Тав. Бусад

5.1 Өрхийн эрүүл мэндийн төв нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ.

5.1.1 Төсвийн тухай хууль болон Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй санхүүгийн эрх зүйн актуудыг чанд мөрдөж, өр авлага үүсгэлгүй ажиллана.

5.1.2 Төсвийн гүйцэтгэлийн мэдээг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан бараа, үйлчилгээний зардлын бүлэглэлээр гарган сар бүр харьяа аймаг, дүүргийн Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

5.1.3 Санхүүгийн тайланг "Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл" стандартын дагуу гаргаж тайлангийн нэгтгэлд хамруулна.

5.1.4 Монгол улсын “Шилэн дансны тухай” хууль болон түүнийг дагалдан гарсан тушаал шийдвэрийн биелэлтийг ханган, төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.

Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын
2015 оны 04 сарын 09 өдрийн 77 дугаар
хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН НЭГ ИРГЭНД НОГДОХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

№	Эрүүл мэндийн эрсдэлийн бүлэг		Нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардлын хэмжээ (төгрөг)
	Насны бүлэг	Оршин суугаа газар	
1	0-5 нас	Гэр хороолол	26,479.3
2		Байшин хороолол	23,276.7
3	6-15нас	Гэр хороолол	11,266.9
4		Байшин хороолол	10,466.3
5	16-49 насны эмэгтэйчүүд	Гэр хороолол	12,067.6
6		Байшин хороолол	12,067.6
7	60 наснаас дээш	Гэр хороолол	16,871.5
8		Байшин хороолол	15,270.1
9	Бусад*	Гэр хороолол	9,665.6
10		Байшин хороолол	8,865.0

*-16-49 насны эрэгтэйчүүд, 50-59 насны эрэгтэй, эмэгтэйчүүд